



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/678

Есөнбулаг

Үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх Бигэр, Хөхморьт, Цээл сумдын Эрүүл мэндийн төвд автомашин худалдан авах ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга	Э.Энхболд	(Ундарга-Алтай ААТҮГ-ын дарга)
Гишүүдэд:	Д.Ганширэм	(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)
	Ё.Нарангарав	(Хөндлөнгийн төлөөлөл) (тохиролцсон)
	Г.Алтангадас	(Есөнбулаг сумын иргэн)
Нарийн бичгийн дарга:	Б.Эрхбаяр	(Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай зохион байгуулан, дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг Үнэлгээний хороо (Э.Энхболд)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

